



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/223

Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран  
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд  
шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 5 дугаар сарын 1-ээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 2 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 77, 2008 оны 88 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

480010663

Засаг даргын 2020 оны 09 дугаар сарын 11-ны  
 өдрийн 4/223 дугаар захирамжийн хавсралт



№	Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн			Газар өмчлөх эрх шилжүүлсэн			Газрын хэмжээ /м2/	Газрын үнэ	
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистр	Овог нэр	Регистр			
1	Хан	Жигмэддорж	Жасрай	ЗНО95061419	Ж.Даваадорж Ж.Лувсанцэрэн	ЗФ90012910 ЗНО92011513	Боржигон 16-1618	978	1956000
2	Баяуд	Мөнхбаяр	Төгөлдөр	ЗНО97060314	Ж.Нарантуяа	ЗНО63050243	Тосгон 12-1201	1200	1800000